



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2016 оны 03 сарын 09 өдөр

Дугаар 1732

Сүхбаатар сум

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 74 тоот тогтоолоор батлагдсан орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэн хэрэгжих зарим төсөл арга хэмжээний эрхийг шилжүүлсүгэй.

2.Эрх шилжүүлэх хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээний жагсаалт, төсвийн шууд захирагч нарын нэр дээр тус бүрээр хавсралтаар баталсугай.

3.Эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээний худалдан авалтыг хуулийн дагуу гүйцэтгэгчийг шалгаруулах, шалгаруулсан баримт бичгийг Худалдан авах ажиллагааны алба, Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлогын хэлтэст хянуулж, Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргаар баталгаажуулан санхүүжилтийг зарцуулах, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг сум, агентлагийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

С.БҮРЭНБАТ

Аймгийн Засаг даргын 2016 оны
03-р сарын 09-ний өдрийн
А/52 тоот захирамжийн хавсралт

**СЭЛЭНГЭ АЙМАГТ 2016 ОНЫ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЗАХИАЛАГЧИЙН ЭРХИЙГ
СУМД, БАГУУЛЛАГУУДАД ШИЛЖҮҮЛСЭН ХУВААРЬ**

№	Д/д	Төсөл арга хэмжээний нэр, хүчин чадар, байршил	Батлагдсан Төсөвт өртөг /мянган төгрөг/	Эрх хүлээн авах сумд, хэлтэс, агентлагийн даргын нэрс
ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ:				
1	1.1.1	Орхонтуул сумын хүүхэд хөгжлийн төвийн барилга барих	108,000.0	Орхонтуул сумын Засаг дарга С.Эрдэнэбаяр
2	1.1.17	Сант суманд наадмын талбай барих	75,000.0	Сант сумын Засаг дарга Д.Өлзийбадрах
3	1.1.18	Орхон суманд наадмын талбай барих	75,000.0	Орхон сумын Засаг дарга Г.Булганчимэг
4	2.1.2	Үүлэнд зориудаар нөлөөлж хур тунадас оруулах, нөөцийн пуужин авах	45,000.0	УЦУОША-ны дарга Б.Рэгзэдмаа
		ДҮН	303,000.0	